

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/261-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-2442	Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Цахим хаяг: narantsetsegba@audit.gov.mn
Сүхбаатар сум 2023 он		

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-16
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
МЭН	Мал эмнэлгийн нэгж
МЭУСАХЗ	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОХУ	Оросын Холбооны Улс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам



СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН
ГАЗРЫН ДАРГА С.АРИУНТӨГС ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.14 № СЭА-2023/261-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 90.4 хувьтай тайлагнагдан, орон тоо дутуу ажилласнаас голлон шалтгаалж батлагдсан төсвийг 9.6 хувиар хэмнэсэн байна.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд МЭЕГ-аас 3 төрлийн өвчний тарилгын үйлчилгээний хөлс 386,294.9 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас МЭУСАХЗ-ын 397,100.0 мянган төгрөг гэх зэрэг нийт 803,937.2 мянган төгрөг төвлөрүүлснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 59.2 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд тайлант онд мал эмнэлгийн үйлчилгээний 45 нэгжид улсын төсвөөс 619,256.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 264,017.8 мянган төгрөгийн урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлс олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	232,427,519.84	207,063,828.84
34	УРЬДЧИЛГАА	7,200,000.00	0
34600	Урьдчилж гарсан зардал	7,200,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	225,227,519.84	207,063,828.84
35100	Түүхий эд материал	128,692,718.54	114,987,549.54
35130	Эм боох материал	128,692,718.54	114,987,549.54
35400	Хангамжийн материал	96,534,801.30	92,076,279.30
35410	Бичиг хэргийн материал	1,507,400.00	353,250.00
35420	Аж ахуйн материал	1,032,642.50	1,120,142.50
35440	Түлш, шатах тослох материал	4,013,900.00	3,878,820.00
35470	Бусад хангамжийн материал	89,980,858.80	86,724,066.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,676,821,275.96	1,567,694,086.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,676,821,275.96	1,567,694,086.43
39200	Биет хөрөнгө	1,581,251,942.70	1,433,165,753.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	56,613,718.93	53,712,918.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,386,375.60	-22,140,563.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165,931,300.00	148,356,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-58,752,653.44	-61,585,363.44
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,450,130,281.00	1,548,730,409.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-157,101,390.18	-358,946,357.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	171,403,548.60	169,580,548.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,586,486.61	-44,542,139.14
39300	Биет бус хөрөнгө	95,569,333.26	134,528,333.26
39301	Программ хангамж	2,280,000.00	2,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-838,666.74	-1,294,666.74
39303	Бусад биет бус хөрөнгө	94,128,000.00	133,543,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,909,248,795.80	1,774,757,915.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	156,194.32	49,785,750.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	156,194.32	49,785,750.00
41300	Өглөг	156,194.32	49,785,750.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	156,194.32	0
41360	Бусад өглөг	0	49,785,750.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	49,785,750.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,909,092,601.48	1,724,972,165.27
51	Засгийн газрын хувь оролцоо	1,909,092,601.48	1,724,972,165.27
51101	-Төрийн	0.00	39,415,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,909,092,601.48	1,685,557,165.27
51210	Өмнөх үеийн үр дүн	683,696,737.50	1,909,092,601.48
51220	Тайлант үеийн үр дүн	1,225,395,863.98	-223,535,436.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,909,248,795.80	1,774,757,915.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Аудит
Төгрөгөөр
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,526,806,129.46	2,516,111,292.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,263,567,668.34	786,392,032.65
120	Нийтлэг татварын бус орлого	2,263,567,668.34	786,392,032.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,921,140.00	10,833,450.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,921,140.00	10,833,450.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,275,215,424.80	81,463,519.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	983,431,103.54	694,095,063.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,263,238,461.12	1,729,719,259.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	817,560,100.00	925,871,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	817,560,100.00	925,871,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	445,678,361.12	803,847,659.90
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	407,974,311.12	403,510,499.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,704,050.00	400,337,160.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,301,410,265.48	2,739,646,728.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,301,410,265.48	2,739,646,728.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,214,878,646.40	2,621,872,183.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	442,385,605.51	440,157,409.17
210101	Үндсэн цалин	331,322,235.23	343,823,260.29
210102	Нэмэгдэл	95,413,498.61	48,286,809.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,649,871.67	24,715,100.00
210104	Урамшуулал	0	23,332,239.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,498,964.41	59,748,214.33
210201	Тэтгэврийн даатгал	40,099,918.41	38,400,347.76
210202	Тэтгэмжийн даатгал	4,468,165.01	4,517,687.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,027,576.36	8,018,438.07
210204	Ажилгүйдлийн даатгал	809,391.81	801,067.65
210205	Эрүүл мэндийн даатгал	8,093,912.82	8,010,672.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,270,494.32	20,007,897.90
210301	Гэрэл, цахилгаан	5,092,994.32	7,079,797.90
210302	Түлш, халаалт	12,177,500.00	12,928,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,827,895.00	33,833,590.00
210401	Бичиг хэрэг	2,584,600.00	3,343,290.00
210402	Тээвэр, шатахуун	36,813,795.00	22,306,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,392,400.00	5,127,520.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,037,100.00	3,056,020.00
2105	Нормативт зардал	941,480,252.70	808,568,939.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	941,000,252.70	808,438,939.12
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	480,000.00	130,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,730,000.00	4,700,900.00
210604	Урсгал засвар	6,730,000.00	4,700,900.00
2107	Томилолт, зочны зардал	17,018,300.00	14,653,400.00
210702	Дотоод албан томилолт	17,018,300.00	14,653,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	393,934,160.12	942,123,648.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	388,896,779.12	932,850,249.90
210803	Даатгалын үйлчилгээ	573,100.00	573,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	357,720.00	358,520.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	341,000.00	4317,297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	7,785,000.00
210807	Газрын төлбөр	165,561.00	259,779.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	288,732,974.34	298,078,184.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,741,045.50	44,372,475.53
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	175,991,928.84	253,705,708.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,531,619.08	117,774,545.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,660,000.00	25,124,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	21,705,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,660,000.00	3,419,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	82,871,619.08	92,649,645.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,871,619.08	92,649,645.28
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,225,395,863.98	-223,535,436.21
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,225,395,863.98	-223,535,436.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Атгалаа
МОНГО
Аудит
Төгрөгөөр/
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,268,159,601.12	1,740,552,709.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,921,140.00	10,833,450.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,921,140.00	10,833,450.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,921,140.00	10,833,450.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,921,140.00	10,833,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,263,238,461.12	1,729,719,259.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	817,560,100.00	925,871,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	817,560,100.00	925,871,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	445,678,361.12	803,847,659.90
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	407,974,311.12	403,510,499.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,704,050.00	400,337,160.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,264,309,601.12	1,716,852,709.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,264,309,601.12	1,716,852,709.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,177,777,982.04	1,599,078,164.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	442,385,604.34	440,157,409.17
210101	Үндсэн цалин	331,322,234.06	350,052,576.03
210102	Нэмэгдэл	95,413,498.61	45,541,970.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,649,871.67	22,429,392.50
210104	Урамшуулал	0	22,133,469.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,498,965.58	59,748,214.33
210201	Тэтгэврийн даатгал	40,099,920.67	38,400,347.76
210202	Тэтгэмжийн даатгал	4,468,165.05	4,517,687.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,027,576.34	8,018,438.07
210204	Ажилгүйдлийн даатгал	809,391.74	801,067.65
210205	Эрүүл мэндийн даатгал	8,093,911.78	8,010,672.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,073,800.00	20,435,772.22
210301	Гэрэл, цахилгаан	4,936,800.00	7,235,992.22
210302	Түлш, халаалт	15,137,000.00	13,199,780.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,827,904.00	30,674,670.00
210401	Бичиг хэрэг	3,420,900.00	2,169,640.00
210402	Тээвэр, шатахуун	34,667,704.00	21,346,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,392,400.00	5,127,520.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,346,900.00	2,031,150.00
2105	Нормативт зардал	183,961,388.00	141,968,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	183,481,388.00	141,838,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	480,000.00	130,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,102,000.00	4,700,900.00
210604	Урсгал засвар	7,102,000.00	4,700,900.00
2107	Томилолт, зочны зардал	17,018,300.00	14,653,400.00
210702	Дотоод албан томилолт	17,018,300.00	14,653,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	401,774,160.12	885,137,898.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	389,536,779.12	883,064,499.90
210803	Даатгалын үйлчилгээ	573,100.00	573,100.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	357,720.00	358,520.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	341,000.00	297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	585,000.00
210807	Газрын төлбөр	165,561.00	259,779.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,860.00	1,601,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	135,860.00	1,601,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,531,619.08	117,774,545.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,660,000.00	25,124,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	21,705,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,660,000.00	3,419,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	82,871,619.08	92,649,645.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,871,619.08	92,649,645.28
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,850,000.00	23,700,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,850,000.00	23,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,850,000.00	23,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,850,000.00	23,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,850,000.00	23,700,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,850,000.00	-23,700,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	683,696,737.50	683,696,737.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	683,696,737.50	683,696,737.50
4	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
5	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
6	Тайлант үеийн үр дүн	0	0	1,225,395,863.98	1,225,395,863.98
7	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	1,909,092,601.48	1,909,092,601.48
8	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	1,909,092,601.48	1,909,092,601.48
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	1,909,092,601.48	1,909,092,601.48
11	Өмчид гарсан өөрчлөлт	39,415,000.00	0	0	0
12	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
13	Тайлант үеийн үр дүн	0	0	-223,535,436.21	-223,535,436.21
14	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	39,415,000.00	0	1,685,557,165.27	1,724,972,165.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан



Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	933,371,600.00	844,055,404.72	89,316,195.28	90.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	933,371,600.00	844,055,404.72	89,316,195.28	90.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	910,245,800.00	820,930,504.72	89,315,295.28	90.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	523,628,600.00	440,157,409.17	83,471,190.83	84.06
210101	Үндсэн цалин	402,616,800.00	350,052,576.03	52,564,223.97	86.94
210102	Нэмэгдэл	68,045,800.00	45,541,970.79	22,503,829.21	66.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,366,000.00	22,429,392.50	3,936,607.50	85.07
210104	Урамшуулал	26,600,000.00	22,133,469.85	4,466,530.15	83.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,453,500.00	59,748,214.33	5,705,285.67	91.28
210201	Тэтгэврийн даатгал	40,558,400.00	38,400,347.76	2,158,052.24	94.68
210202	Тэтгэмжийн даатгал	5,236,200.00	4,517,687.96	718,512.04	86.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,139,000.00	8,018,438.07	120,561.93	98.52
210204	Ажилгүйдлийн даатгал	1,047,300.00	801,067.65	246,232.35	76.49
210205	Эрүүл мэндийн даатгал	10,472,600.00	8,010,672.89	2,461,927.11	76.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,436,800.00	20,435,772.22	1,027.78	99.99
210301	Гэрэл, цахилгаан	7,236,000.00	7,235,992.22	7.78	100.00
210302	Түлш, халаалт	13,200,800.00	13,199,780.00	1,020.00	99.99
2104	Хангамж, бараа материалын зардал	18,689,800.00	18,688,010.00	1,790.00	99.99
210401	Бичиг хэрэг	2,169,900.00	2,169,640.00	260.00	99.99
210402	Тээвэр, шатахуун	9,359,700.00	9,359,700.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,128,000.00	5,127,520.00	480.00	99.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,032,200.00	2,031,150.00	1,050.00	99.95
2105	Нормативт зардал	17,894,600.00	17,881,900.00	12,700.00	99.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,763,600.00	17,751,900.00	11,700.00	99.93
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	131,000.00	130,000.00	1,000.00	99.24
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,483,400.00	26,400,900.00	82,500.00	99.69
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,279,000.00	3,200,000.00	79,000.00	97.59
210604	Урсгал засвар	23,204,400.00	23,200,900.00	3,500.00	99.98
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.00	2,481,400.00	18,600.00	99.26
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	2,481,400.00	18,600.00	99.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	235,046,500.00	235,035,399.00	11,101.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	232,962,000.00	232,962,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	573,100.00	573,100.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	358,600.00	358,520.00	80.00	99.98
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	308,000.00	297,000.00	11,000.00	96.43
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	585,000.00	585,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	259,800.00	259,779.00	21.00	99.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,600.00	101,500.00	11,100.00	90.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,600.00	101,500.00	11,100.00	90.14

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,125,800.00	23,124,900.00	900.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,125,800.00	23,124,900.00	900.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,705,900.00	21,705,900.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,419,900.00	1,419,000.00	900.00	99.94
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	933,371,600.00	844,055,404.72	89,316,195.28	90.43
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	925,871,600.00	833,221,954.72	92,649,645.28	89.99
310001	Улсын төсвөөс санхүүжих	925,871,600.00	833,221,954.72	92,649,645.28	89.99
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,500,000.00	10,833,450.00	-3,333,450.00	144.45
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,500,000.00	10,833,450.00	-3,333,450.00	144.45
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	51	37	14	72.5
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	48	32	16	66.7
620003	Үйлчлэх ажилтан	2	4	-2	200.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөгөөр/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	803,847,659.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	803,847,659.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	801,847,659.90
2104	Хангамж, бараа материалын зардал	11,986,660.00
210402	Тээвэр, шатахуун	11,986,660.00
2105	Нормативт зардал	126,086,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	126,086,500.00
2107	Томилолт, зочны зардал	12,172,000.00
210702	Дотоод албан томилолт	12,172,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	650,102,499.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	650,102,499.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	803,847,659.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	803,847,659.90
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	403,510,499.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	400,337,160.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газар /цаашид Мал эмнэлгийн газар гэх/ нь “Төрөөс мал эмнэлгийн талаар хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг орон нутагт зөв зохион байгуулж хэрэгжүүлэх замаар мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэж халдварт өвчингүй тайван газар нутгийг дотооддоо баталгаажуулан хадгалах, малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд шууд нөлөөлөх мал эмнэлгийн ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж зах зээлд нийлүүлэгдэх хүнсний аюулгүй байдлыг хангах, боловсруулах үйлдвэрт нийлүүлэгдэх түүхий эдийн чанарт ахиц дэвшил гаргах, малчин өрхийн санхүүгийн чадавхыг сайжруулахад бодитой үр нөлөө үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107, 05 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолоор “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ”-г шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мал эмнэлгийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдэж, санхүү, бүртгэлтэй холбоотой 6 зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/385 дугаар тушаалаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.


Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 134,914.1 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилгаа	7,200.0	-	(7,200.0)
Бараа материал	225,227.5	207,063.8	(18,163.7)
Үндсэн хөрөнгө	1,676,821.3	1,567,694.1	(109,127.2)
Нийт хөрөнгө	1,909,248.8	1,774,757.9	(134,490.9)
Өр төлбөр	156.2	49,785.8	49,629.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,909,092.6	1,724,972.1	(184,120.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,909,248.8	1,774,757.9	(134,490.9)

2021 оны эцэст “Даталанд технологи” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу төсвийн хяналтын нэгдсэн opengov.mn программын үйлчилгээний хөлсөнд 7,200.0 мянган төгрөгийг төлснөөр урьдчилж гарсан зардлын үлдэгдэлтэй тайлагдаж, тайлант онд гэрээт ажлыг хэрэгжүүлснээр уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 207,063.8 мянган төгрөг болж 18,163.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 185,201.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, НИК шатахуун түгээх газраас 553.6 мянган төгрөгийн шатахууныг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, МЭЕГ-аас 693,541.4 мянган төгрөгийн вакцин, оношлуур, эм боох материалыг шилжүүлэн авсан болон 897,459.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,056,203.2 мянган төгрөг болж 115,716.3 мянган төгрөгөөр өсөхөд дараах хүчин зүйлүүд голлон нөлөөлсөн байна Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 23,700.0 мянган төгрөгийн уурын зуухны тогоо, тоног төхөөрөмж худалдан авсан,
- 118,013.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж болон газрыг МЭЕГ, аймгийн ЗДТГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг 2,865.0 мянган төгрөгөөр дахин үнэлж орлого авсан,
- Аймгийн ОНӨГ-ын 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 190 дүгээр албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу 17,575.0 мянган төгрөгийн 1 автомашиныг акталж, данс бүртгэлээс хассан,
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 11,287.2 мянган төгрөгийн хөрөнгийн дансны үнийг бууруулсан гэх мэт.

Тайлант оны эхэнд 156.2 мянган төгрөгийн гэрэл цахилгааны төлбөрийн үлдэгдэлтэй байсныг тайлант хугацаанд төлж барагдуулсан бөгөөд малын халдварт бруцеллёз болон галзуу, томуу, мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсний санхүүжилтийг дутуу олгосноос мал эмнэлгийн 45 нэгжид өгөх нийт 49,629.6 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,724,548.9 мянган төгрөг болж 184,543.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Мал эмнэлгийн газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 909,432.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 260,878.5 мянган төгрөгөөр бууруулж, 648,553.8 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, 89.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлжээ.
Үүнд:

- УМЭАЦТЛ-оос 4 төрлийн тандалт шинжилгээний зардалд 14,042.3 мянган төгрөг,
- МЭЭГ-аас 3 төрлийн өвчний тарилгын үйлчилгээний хөлс 386,294.9 мянган төгрөг,
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас МЭУСАХЗ-ын 397,100.0 мянган төгрөг,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс дархлаажуулалтын аян зохион байгуулах шатахууны зардал 3,000.0 мянган төгрөг, байгууллагын шагнал урамшуулалд 2,000.0 мянган төгрөг, ОХУ-ын Буриад Улсад зохион байгуулагдах сургалтад оролцоход зориулан 1,500.0 мянган төгрөг зэрэг.

Нэмэлт төсвийн орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,301,410.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,014.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Тайлант онд хэвлэл захиалга хийгээгүй,
- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг хэмнэсэн,
- Сургалт, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрт шилжүүлж холбогдон гарах зардлыг хэмнэсэн,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Байгууллагын дулаан, цахилгааны хэрэглээнд албан хаагчдыг хэмнэлттэй байх үүрэг даалгавар өгч, үр ашиггүй зардал гаргахгүй ажиллаж, өр төлбөргүй тайлагнагдсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мал эмнэлгийн газар нь мэдээлбэл зохих 27 нэр төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.


Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Дээд шатны төсвийн захирагч буюу ХХААХҮ-ийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар баталсан орон тооноос жолооч, сахиулыг тус бүр 1 -ээр хэтрүүлэн, өвлийн улиралд уурын зуухны галчийг гэрээгээр ажиллуулж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн

байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баталсан орон тоо хэтрүүлэн гэрээгээр ажиллуулж буй ажилтнуудыг чөлөөлөх албан шаардлага хүргүүлэх.



4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар албан хаагчдад унаа, хоолны хөнгөлөлтийг албан томилолтын хоолны зардалтай давхардуулан олгосон зөрчил илэрснийг 2023 оны төсөвт нөхөн тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж бус оны эхэнд тушаал гаргаж, бүтэн жилийн турш олгосон болон 2,225.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зэрэг 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг аудитаар дахин хянахад 50.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	2,225.3	1		50
Нийт дүн	2	2,225.3	1		50


Өмнөх онд өгөгдсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн

санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

Дээд шатны төсвийн захирагч буюу ХХААХҮЯ-ны 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/351 дүгээр албан бичгээр тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”-ний дагуу тогтоох чиглэл өгсний дагуу 1-3 дугаар сарын цалинг дээрх сүлжээгээр тооцож, 9 албан хаагчид 1,118.4 мянган төгрөгийн цалин хөлс илүү олгосон байна.



5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бүртгээгүй 4,400.0 мянган төгрөгийн болон шатахууны зарцуулалтыг 423.2 мянган төгрөгөөр илүү тусгаж, тайлагнасан зэрэг нийт 4,823.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 2,818.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 2,818.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

5.1.1 Албан хаагчдыг сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд унаа, хоолны хөнгөлөлт 1,954.4 мянган төгрөгийг давхардуулан тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон унаа, хоолны хөнгөлөлтийг 2023 оны төсөвт нөхөн суутгах албан шаардлага хүргүүлэх.

5.1.2 Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 864.5 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д *“Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5-д *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ...”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх *“Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”*, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй малын байр, хашаа зэрэг хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоож, элэгдлийн зардлыг тооцоогүй байна. Энэ нь Нягтлан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, НБББББ-ийн “Үндсэн хөрөнгийн бүртгэлийн 5.4.7-д үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй малын байр, хашаа зэрэг хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоож, элэгдлийн зардлыг тооцох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл



Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Давхардуулан зарлагдсан шатахууны бүртгэлийг залруулав.	1	423.2			1	423.2	1	423.2				
Жолоочийн тооцооны хуудасны бүрдлийг хангуулав.	1	4,400.0	1	4,400.0			1	4,400.0				
Дүн	2	4,823.2	1	4,400.0			2	4,823.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Унаа, хоолны хөнгөлөлтийг илүү тооцож олгосон.	1	1,954.4			1	1,954.4						
Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан.	1	864.5			1	864.5						
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй.	1						1					
Дүн	3	2,818.9			2	2,818.9	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Гэрээт ажилтан ажиллуулсан		1					1	
Дүн		1					1	
Нийт дүн		1					1	